



“ЭРДЭНЭТ УЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ УЙЛДВЭРИЙН ГАЗАР

Нийрамдал талбай, Баян-Өндер сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.03.13 № С7-112-18/952
танай -ны № -т

Г Тодруулгын хариу хүргүүлэх тухай Г

“Эрдэнэт уйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Ширмэн хаалтууд” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102130 дугаартай тендерт оролцохыг сонирхогчдоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим (tender.gov.mn) системээр дамжуулан гаргасан тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ

612407005396

ТОДРУУЛГА

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хэрэгцээт “Ширмэн хаалтууд” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102130 дугаартай тендерт оролцохыг сонирхогчдоос дараах тодруулга гарсан байна. Үүнд:

Тодруулга:

Өдрийн мэнд

ШИРМЭН ХААЛТУУД НИЙЛҮҮЛЭХИЙГ СОНИРХОГЧДОД зориулан гаргасан 2024.03.05 өдрийн ДҮ-112-12/796 тоот Хариу хүргүүлэх тухай Тодруулгад :

Хавсралтаар ирүүлсэн хариуны ТШЗ 18.1.2 гэсэн заалт нь ТШББ-т заасантай илт зөрүүтэй байгаа тул нягталж үзнэ үү.

Тодруулгын хариу:

2024 оны 03 дугаар сарын 05 өдрийн ДҮ-112-12/796 албан бичгээр хүргүүлсэн тодруулгын хариу нь захиалагчийн тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн “**ТШЗ 18.1.2** болон **ТШЗ 19.1** дэх заалтын мэдээллийг зөрүүтэй хүргүүлсэн байгааг залруулж байна.

ҮҮНД:

ТШЗ 18.1 Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл Ижил төстэй бараа нийлүүлж байсан туршлагыг дараах байдлаар нотолно. Үүнд:

1. 2021, 2022 оны аль нэг жилд "Төрөл бүрийн хаалт" бараа нийлүүлж байсныг ойлгоно.
2. Бараа нийлүүлсэн гэрээ ба гэрээ дүгнэсэн акт (протокол эсхүл дүгнэлт эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг)-ын хуулбарыг нотариатаар гэрчлүүлж ирүүлнэ. (Хэрэв “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан гэрээ бол нотариатаар батлуулах шаардахгүй)
3. Оролцогч нь V бүлгийн Маягт 3 “Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл”, Маягт 5 “Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл”-ийн дагуу мэдээллийг бэлтгэн ирүүлнэ.

1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022 оны аль нэг жилд тендерийн төсөвт өртгийн 80 хувиас багагүй байна.

2. Тендерт оролцогч нь 2021, 2022 он тус бүр ашигтай ажилласан байна..

ТШЗ 19.1 Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх :“Тийм” 1. Оролцогчийн 2021, 2022 он тус бүрийн санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж, баталгаажсан байх шаардлагатай. Санхүүгийн тайлан цахим бүртгэлд шивэгдэж, баталгаажаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн:

Тендерт оролцогчийн санал болгож буй үнийн 100 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:

[Байгууллагын харилцагч банкан дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа / Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт / Үнэт цаас, Засгийн газрын бонд боон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд]

3. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байна. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. Оролцогч “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.

Жич: 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр дамжуулан тендерт оролцогчдын баталгаажсан санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.

4. Гадаадын хуулийн этгээд бол 2021, 2022 он тус бүрийн санхүүгийн аудитын дүгнэлтийг тендертээ хавсарган ирүүлнэ.” гэж тус тус заасан байх ба батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичигт шаардсаны дагуу материалыг бүрдүүлж ирүүлэхийг анхаарна уу.

Үнэлгээний хорооны дарга
Үнэлгээний хорооны нарийн
бичгийн дарга

Гишүүн:

Т.Атарбаяр

Ч.Отгонбаатар

Д.Батболд

Д.Гансүх

Л.Алтанцэцэг

С.Ганзориг

Б.Халиунаа

ТОДРУУЛГА

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хэрэгцээт “Ширмэн хаалтууд” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102130 дугаартай тендерт оролцохыг сонирхогчдоос дараах тодруулга гарсан байна. Үүнд:

ТОДРУУЛГА:

Өглөөний мэнд

ТТ-ын 5-р барааны 1-р баганан дахь нэр "Задвижка 30с925бр цах. Резиндсэн хавхлагтай Ру- 10 Ду800" гэж заасан байтал, 2-р баганан дахь үзүүлэлт хэсэгт "Загвар: 30с927нж эсхүл түүнтэй дүйцэх САЗ Ду800 Ру25" гэж хоорондоо загвар, материалын зөрүүтэй байгааг тодруулж өгнө үү.

ТОДРУУЛГЫН ХАРИУ:

Захиалагчийн тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтын бүх заалтын 2-р баганад **“ҮЗҮҮЛЭЛТ”** хэсэгт байгаа техникийн үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийхийг анхаарна уу.

Захиалагчийн тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтын 1-р баганад **“СЭЛБЭГ, МАТЕРИАЛЫН НЭР”** хэсэгт зөвхөн барааны нэр байх бөгөөд тухайн бараанд санал болгож буй барааны нэрийг бичиж ирүүлэх ёстой. Энэхүү 1-р баганад **“СЭЛБЭГ, МАТЕРИАЛЫН НЭР”** хэсэгт бичигдсэн мэдээлэлд үнэлгээ хийхгүй.

Үнэлгээний хорооны дарга
Үнэлгээний хорооны нарийн
бичгийн дарга

Гишүүн:

 Т.Атарбаяр

 И.Отгонбаатар

 Д.Батболд

 Д.Гансүх

 Л.Алтанцэцэг

 С.Ганзориг

 Б.Халиунаа